

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН
2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2015 он

Өлгий

*Нэг: Төсвийн төсөл, зарцуулалт, үйл ажиллагааны болон
аудитын болон санхүүгийн тайлан;*

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2015 ОНЫ ТӨСӨВ, ТҮҮНИЙ ЗАРЦУУЛАЛТ				
д/д	Зардлын төрөл	2015 оны төсөв	2015 оны төсвийн гүйцэтгэл	Нийт төсөвт эзлэх хувь
1	Цалингийн зардал	1.358.817.400	1.358.817.400	81.37 %
2	Үндсэн цалин	1.358.817.400	1.358.817.400	81.37 %
3	Тогтмол зардал	84.924.000	84.924.000	5.08 %
4	Гэрэл цахилгаан	7.676.500	6.868.990	0.41 %
5	Түлш халаалт	67.832.600	69.954.280	4.19 %
6	Цэвэр, бохир ус	9.414.900	8.003.666	0,48 %
7	Бараа, ажил үйлчилгээний бусад зардал	226.236.800	226.333.864	13.55%
8	Нийт дүн	1.669.978.200	1.669.978.200	100%

Хоёр: Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг нэвтрүүлэх бодлогын хэрэгжилт, түүний үр дүн;

2.1. Хууль зүйн яамнаас зарласан “Баян-Өлгий аймгийн Өлгий суманд телекамерын систем нийлүүлэх, суурилуулах” тендерт “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах” тухай Монгол Улсын хуулийн 29 дүгээр зүйлийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасны дагуу шаардлага хангасан компаниар “МироТек”, “Лийдлинк” түншлэлийн компаниуд шалгарч 2014 оны 07 дугаар сарын 26-ны өдөр 65 дугаартай гэрээ байгуулсан.

Уг гэрээний дагуу “МироТек”, “Лийдлинк” түншлэлийн компаниуд нь улсын төсвийн 806.875.243 төгрөгийн санхүүжилтээр тус аймгийн Өлгий сумын нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг эмзэг 38 цэгт 49 хяналтын камер, 2 км урттай гудамж талбайд 66 ширхэг гэрэлтүүлэг суурилуулах, хяналтын төвийг цагдаагийн газарт төвлөрүүлэн төв серверийн өрөөг тохижуулах ажлуудыг 2015 оны 06 дугаар сарын 12-ны өдөр дуусгаж, 2015 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр эцсийн байдлаар хүлээлгэн өгсөн. Эдгээр хяналтын камерууд нь Швед Улсад үйлдвэрлэгдсэн “AXIS” фирмийн хамгийн сүүлийн үеийн дэвшилт технологи бүхий IP камерууд бөгөөд авто машины дугаар илрүүлэгч, хөдөлгөөнт, хөдөлгөөнгүй гэсэн төрлүүдээс бүрддэг.

“Телехяналтын нэгдсэн систем”-д холбогдсоноор гудамж талбайд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, таслан зогсоох, цаг алдалгүй шуурхай илрүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг нөхөн илрүүлэх, иргэдийн амар тайван, аюулгүй орчинд амьдрах баталгааг хангахад чухал ач холбогдолтой юм.





Хяналтын камерийн тусламжтайгаар 2015 оны 09 дүгээр сарын 24-ний өдрөөс 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдөр хүртлэх нийт 81 хоногийн хугацаанд хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөн нийт 401 зөрчлийг илрүүлэн, зөрчлийн нотлох баримтыг хэвлэн гаргаж, зөрчил гаргасан этгээдийн хаягаар нь хүргүүлэх ажлыг зохион байгуулж, нийт 4.233.600 төгрөгний торгууль ногдуулсан бөгөөд хяналтын камерийг ажиллуулахад шаардагдах урсгал зардал болох 9.000.000 /есөн сая/ орчим төгрөгийг аймгийн 2016 оны төсвөөс шийдвэрлүүлэв.



2.2. Хүний эрх, эрх чөлөөг хангах, алба хаагч нарын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл, эмнэлгийн үйлчилгээ MNS 5527:2013 стандарт шаардлагыг хангах үүднээс тус Цагдаагийн газрын Саатуулах /хуучинаар эрүүлжүүлэх/ байранд 10.000.000 /арван сая/ төгрөгний урсгал засвар хийж дуусгасан.



2.3. Хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, аюулгүй байдлыг хангах, шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх ажлын хүрээнд ЦЕГ-ын төсвөөс 11.800.000 /арван нэгэн сая найман зуун мянган/ төгрөгийг шийдвэрлүүлж, тус цагдаагийн газрын саатуулах байрыг хяналтын камерийн нэгдсэн сүлжээнд холбох ажлыг эхлүүлээд байна.



Гурав: Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах, бүртгэх ажилтай холбоотой мэдээлэл;

3.1. Тус Цагдаагийн газар 2015 онд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шинжтэй 2874 гомдол, мэдээлэл хүлээн авч, нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 2825-г шийдвэрлэсэн. Үүнээс гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 1199-г хүлээн авч, 979 буюу 81.7 хувийг хуулийн анхны хугацаанд, 220 буюу 18.3 хувийг 6-19 хоногт тус тус шийдвэрлэж, одоо үлдэгдэл 49 гомдол мэдээллийг хуулийн хугацаанд нь шалгаж байна.

Нийт хүлээн авсан гомдол, мэдээллийн 878-г нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах саналаар прокурорт хүргүүлж, 295-н гомдол, мэдээлэлд эрүүгийн хэрэг үүсгэж, 26 гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэгт нэгтгэн шалгаж, 28 гомдол мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлж, 1526 материалд захиргааны арга хэмжээ авч, 72 гомдол, мэдээллийг бусад байдлаар шийдвэрлэсэн.

Гэмт хэргийн ангилалын талаар:

Гэмт хэргийг ангилалаар авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэтэй харьцуулахад хөнгөн, хүнд, онц хүнд хэргийн гаралт 14.4-62.5 хувиар тус тус буурч, хүндэвтэр хэрэг 46.5 хувиар өссөн.

Үүнд: Хүнийг санаатай алах гэмт хэрэг 33.3 хувиар, хүчиндэх гэмт хэрэг 66.6 хувиар, бусдын өмчийн ашиглалын гэмт хэрэг 50 хувиар, бусдын бие махбодид санаатай гэмтэл учруулах гэмт хэрэг 21 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг

гэмт хэрэг 18 хувиар, бусдын эд хөрөнгийг залилан авах гэмт хэрэг 66.6 хувиар, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 20.8 хувиар, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг 21.9 хувиар тус тус буурч, танхайрах гэмт хэрэг, бусдыг амиа хорлоход хүргэх гэмт, албан тушаалын гэмт хэргүүд тус тус мөн үеийн түвшинд, бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 84 хувиар, үүнээс: иргэдийн өмчийг хулгайлах хэрэг гэмт хэрэг 86 хувиар, малын хулгайн гэмт хэрэг 86 хувиар, авто тээврийн хэрэгслийг хулгайлах гэмт хэрэг 2-оор нэмэгдэж, бусад гэмт хэрэг 13.1 хувиар тус тус өссөн статистик үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өмчид 501.3 сая төгрөгийн хохирол учирсаны 397.7 сая төгрөг буюу 79.3 хувийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлэн ажиллав.

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас захиргааны зөрчлийн шинжтэй 6639 гомдол, мэдээлэл хүлээн авч, үүнээс торгуулийн хуудсаар торгох шийтгэл ногдуулсан бүртгэлд 4011 хүний, шийтгэврээр торгох шийтгэл ногдуулсан бүртгэлд 2136 хүний мэдээ мэдээлэл санд шивэгдэж, 101306.6 төгрөгний торгуулийг 6147 хүнд ногдуулсан байна.

Мөн 167 хүнийг шүүхийн шийдвэрээр захиргааны журмаар 7-30 хоногийн хугацаагаар баривчлуулж, 227 хүний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 06 сараас 2 жилийн хугацаагаар хасах арга хэмжээ авч, архи согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэсэн үедээ зөрчилд холбогдсон 620 хүнийг саатуулав.

Аймгийн хэмжээнд 2015 оны эхний 11 сарын байдлаар 251 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 14 хэргээр буюу 5.3 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан байна.

3.2. Сүүлийн 3 жилийн хугацаанд цагдаагийн ажил, үйлчилгээ шинэ шатанд гарч, нийтэд үзүүлсэн үйлчилгээний цар хүрээ өргөжин нэмэгдсэнээр гэмт хэргийн гаралт 188 гэмт хэрэг буюу 45.9 хувиар буурч, иргэн аж ахуйн нэгж, байгууллагад учирсан 1165,7 төгрөгний хохирлыг нөхөн төлүүлсэн гэх зэрэг эерэг үзүүлэлтүүд гарсан байна.

3.3. 2015 онд нийт 12 сум, 1 тосгонд 12 удаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулсан нь Цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээг сумдад чиглүүлсэн томоохон зохион байгуулалтын арга хэмжээ болохоос гадна 2015 оны 8 суманд дунджаар гэмт хэргийн гаралт 24.7 хувиар буурахад шууд нөлөөлсөн.

3.4. Аймгийн хэмжээнд 2015 онд 287 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд 2014 онтой харьцуулахад 8 хэргээр буюу 2.8 хувиар буурсан.

№	Сумдын нэр	2014 он	2015 он	Харьцуулалт өссөн, буурсан
1	Алтай	18	16	-2 буюу 11.1 %
2	Алтанцөгц	10	7	-3 буюу 30.0 %
3	Баяннуур	14	10	-4 буюу 28.6 %
4	Булган	10	4	-6 буюу 60.0 %
5	Буянт	5	14	+9 буюу 2.6 дахин
6	Бугат	15	10	-5 буюу 33.3 %
7	Дэлүүн	8	7	-1 буюу 12.5 %
8	Ногооннуур	22	23	+1 буюу 13.6 %
9	Цагааннуур	7	6	-1 буюу 14.3 %
10	Сагсай	3	8	+5 буюу 2.5 дахин
11	Толбо	9	14	+5 буюу 1.5 дахин
12	Улаанхус	16	18	+2 буюу 13.3 %
13	Цэнгэл	19	22	+3 буюу 31.2 %
14	Өлгий сум	131	120	-11 буюу 8.4 %

Дөрөв: Цагдаагийн алба хаагчийн сургалт, сахилга, ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээлэл;

4.1. Цагдаагийн газрын тасаг, албадууд 2015 онд дотооддоо болон нэгдсэн байдлаар 232 цаг, давхардсан тоогоор иийт 26040 алба хаагчдыг хамруулсан сургалтыг тус тус зохион байгуулсан. Мөн нийт бие бүрэлдэхүүний нэгдсэн сургалтыг тасаг, хэсэг ээлжлэн зохион байгуулах төлөвлөгөөг гаргаж 1,2,3 дугаар улирлын нэгдсэн цугларалт, сургалт-зөвлөгөөнийг 2015 оны 04, 06, 10 дугаар саруудад тусгай хөтөлбөрийн дагуу амжилттай зохион байгуулаа.

Мөн Цагдаагийн газрын нэгдсэн сургалт, зөвлөгөөний үеэр тасаг, хэсгээс шалгарсан сургалтуудыг тухайн алба хаагч нараар хичээл заалгасан нь оновтой, шинэлэг ажил болсон.

Нийт бие бүрэлдэхүүний дунд албаны бэлтгэлийн сургалт, төрөл бүрийн спортын уралдаан тэмцээнийг 7 хоног тутамд нэг удаа зохион байгуулсан.



Сургалтыг зохион явуулахдаа танхимд олон цагаар суулгаж хичээл зааж алба хаагчдыг залхаадаг хуучны сургалтын аргыг өөрчлөн практик сургалтыг түлхүү явуулж хэвшсэн.



4.2. Өнөөдрийн байдлаар Хууль Сахиулах Их сургуулийн Цагдаагийн сургуулийн эчнээ 5 жилийн сургалттай ангид 8 алба хаагч, 3 жилийн сургалттай ангид 1, Удирдлагын академид 1, хууль сахиулах их сургуулийн магистрт 2, Монголын үндэсний их сургуулийн магистрт 8, нийт 20 алба хаагч суралцаж байна.

Мөн аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран “Архи, тамхины хор хөнөөл” сэдэвт сургалтыг явуулж, алба хаагчдын дунд “Эрүүл бие-Саруул ухаан” арга хэмжээг зохион явуулж ажилласан.

Алба хаагчдын оюуны хэрэгцээг хангах, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор Цагдаагийн газрын сэтгэл зүйчийн өрөөнд өөрсдийн нөөц бололцоог ашиглан шинээр номын сан байгуулав. Номын санд алба хаагч нарт уншигчийн карт нээж, хууль эрх зүйн болон уран зохиолын ном товхимолоор хангаж, төрөл бүрийн сонин, сэтгүүлийг захиалан санг баяжуулан ажилласнаар өнөөдрийн байдлаар 68 төрлийн нийт 2600 ширхэг ном, сонин, сэтгүүлтэй болсон байна.



2015 онд нийт 45 алба хаагч, 85 ном уншсан байна.

4.3. Цагдаагийн газраас 2014 онд 51 алба хаагч сахилга, ёс зүйн зөрчил дутагдал гаргаж, сахилгын арга хэмжээ авагдсан бол 2015 оны байдлаар 38 алба хаагч сахилга, ёс зүйн зөрчил гаргаж, сахилгын арга хэмжээ авагдсан байна.

Сахилгын зөрчлийг өнгөрсөн онтой харьцуулахад 13 алба хаагчаар буюу 25 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зөрчлийг илрүүлсэн байдал:

1. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллээр -15
2. Гадны хяналтаар: - 5 зөрчил
3. Дотоод хяналтаар - 18 зөрчлийг тус тус илрүүлэв.

д/д	Төрөл	Алба хаагчийн тоо
1	Зөрчил гаргасан офицер	32
2	Зөрчил гаргасан ахлагч	5
3	Энгийн	1
Зөрчлийн төрөл		
1	Сануулсан	14
2	Цалин бууруулсан	22
3	Ажлын хариуцлага алдсан	1
4	Архидан согтуурсан	6
5	ЭБШХ зөрчсөн	8
6	Ажил, албанаас халсан	2

Тав: Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тайлан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал;

5.1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр баталсан төлөвлөгөөний дагуу Баруун бүсийн цагдаагийн хүрээний цагдаагийн газрын дарга, хэсгийн төлөөлөгч, хүүхдийн байцаагч нарын “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт, зөвлөгөөнийг Баян-Өлгий аймгийн төв Өлгий хотод 2015 оны 06 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд ёслол төгөлдөр, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулав.



“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” тухай Монгол Улсын хуулийн хэрэгжилтийг хангах, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, алба хаагч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд онцгой ач холбогдолтой ажил болов.



Сургалт, зөвлөгөөнд зориулж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2.000.000 /хоёр сая/ төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 1.000.000 /нэг сая/ төгрөг, нийт 3.000.000 /гурван сая/ төгрөгний туслалцаа, дэмжлэг үзүүлсэн байна.

5.2. Цагдаа-Олон нийтийн хамтын ажиллагаа болон соён гэгээрүүлэх ажлын цар хүрээг өргөжүүлэх, цагдаагийн газрын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор тус Цагдаагийн газрын “Ахмадын зөвлөл”-өөс санаачлан Баян-Өлгий аймагт Цагдаагийн байгууллага үүсч байгуулагдсаны түүхт 75 жилийн ойд

зориулсан “Эргэн дурсахуй” тоглолтыг 2015 оны 05 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд Хөгжимт драмын театрт аймгийн оршин суугчдад 4 удаа сонирхуулав.



Хамтарсан тоглолтын үеэр Монгол Улсад цагдаагийн байгууллага байгуулагдсан түүх, хөгжил, үйл ажиллагааны онцлог, мөн олон нийт цагдаагийн хамтын ажиллагааг харуулсан урлагийн тоглолтуудыг иргэд, олон нийтэд хүртээл болгосноор олон нийт цагдаагийн хамтын ажиллагаа бэхжсэн, иргэдийн зүгээс цагдаагийн байгууллагад итгэх итгэл нэмэгдсэн, хамтын ажиллаганд эерэг хандлага бий болсон зэрэг олон талын ач холбогдолтой ажил болсон.



5.3. Удаа дараа архидан согтуурч зөрчил гарган саатуулагдаж байсан 7 хүнийг архинд донтох өвчтэй талаар эмнэлгийн байгууллагын дүгнэлт гаргуулан, зөрчлийн материал бүрдүүлэн Сум дундын шүүхэд шилжүүлж, архины албадан эмчилгээнд хамруулах шийдвэрийг гаргуулснаар тус аймгийн Өлгий суманд оршин суугч 5 хүнийг 2015 оны 07 дугаар сард Төв аймгийн Баян сум дахь Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт эмчилгээнд хүргэж эмчлүүлсний үр дүнд архинаас бүрэн гарч, иргэдийг амьдралын зөв хэвшилд оруулсан томоохон зохион байгуулалтын арга хэмжээ болов.

Дээрх иргэдийг архины эмчилгээнд хамруулахад шаардагдах замын болон бусад зардал болох 1.500.000 төгрөгийг аймгийн ГХУСЗЗ-д санал хүргүүлэн шийдвэрлүүлсэн.



5.4. Мөн “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор хамтарсан баг 6 иргэнийг “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх хэсэг, 16.1.5 дахь хэсэгт заасныг баримтлан Баян-Өлгий аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр нийт 8 хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ авхуулав.

5.5. Цагдаагийн газрын даргын 2014 оны 03 дугаар 27-ны өдрийн 43 дугаар тушаалаар “Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хэргийн хохирогч, гэрч нарын нарын сэтгэл санааны онцлогийг мэдэрч, тайвшруулах, дахин сэтгэл зүйн таагүй байдалд оруулахгүй байх” зорилго бүхий 4 хүний бүрэлдэхүүнтэй баг томилон ажиллуулж, багийн гишүүд 2015 онд нийт 35 иргэнд сэтгэл зүйн дэмжлэг, үйлчилгээ үзүүлсэн ба Цагдаагийн газрын сэтгэл зүйчийн өрөөг эмзэг хохирогч, гэрчийг хүлээн авч уулзах, хамгаалах өрөө болгон ашиглаж байна.



5.6. Цагдаагийн газрын зүгээс эмзэг бүлгийг дэмжих, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулснаар 2015 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 25 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 7 хэрэг буюу 21.9 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан байна.

5.7. Сумдад архидан согтуурах явдлыг багасгах, хор уршгийг тайлбарлан таниулах зорилгоор аймгийн Засаг даргын 2013 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 32 дугаар захирамжаар батлагдсан “Архины хамааралтай иргэдэд нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх” клубын гишүүдтэй хамтран нийт 8 сумын 121 хүнд архины хор уршиг, зохистой хэрэглээний талаар зөвлөгөө өгч архинаас гаргах арга хэмжээг үе шаттай зохион байгуулав.

5.8. Архидалтаас урьдчилан сэргийлэх ажлыг дэс дараатай, үр дүнтэй зохион байгуулж ажилласны үр дүнд цагдаагийн газрын саатуулах байранд 2015 онд зөрчил үйлдэж, 620 хүн саатуулагдсан нь өнгөрсөн үеийн мөн үетэй харьцуулахад 523 хүнээр буюу 45.7 хувиар, шүүхийн шийдвэрээр баривчлах байранд 165 хүнийг хүлээн авч, шийтгэл эдлүүлсэн нь урьд оны мөн үеэс 87 хүнээр буюу 34.2 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй гарсан.

5.9. Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Өлгий сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэн нарын хамт согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилгээ үзүүлдэг давхардсан тоогоор 59 бөөний төв, 329 хүнсний дэлгүүр, 39 баар, цэнгээний газруудад хяналт, шалгалт явуулж, архидан согтуурахтай тэмцэх тухай Монгол Улсын хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн 57 зөрчилд 2.560.000 төгрөгний торгууль оногдуулан, дээрх зөрчлүүдийн улмаас хураагдсан 183 литр архи, 319 литр пиво, 3 литр дарсыг хурааж, хууль журмын дагуу шийдвэрлэж ажилласан.

5.10. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй эмзэг цэг, гудамж талбай, байр байгууламжийг хяналтанд авах чиглэлээр “Шөнө”, “Хяналт 1, 2, 3”, “Хуулийн хэрэгжилт”, “Хүнсний аюулгүй байдал”, “Чичиргээ”, “Согтууруулах ундаа”, “Согтуу” зэрэг нийт 34 удаа ерөнхий, тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнг нь тооцон ажилласан.

5.11. Гэмт хэрэг, зөрчлийн үйлдэгдэж байгаа байдалд дүн шинжилгээ хийж, Цагдаагийн газрын НХЖХТасгийн алба хаагчид 5640 цаг, ЗЦТасгийн алба хаагчид 14084 цаг зөрчил ихээр үйлдэгдэж байгаа цаг хугацаанд хамтран ажиллаж, өдрийн цагаар аймгийн төвийн хөдөлгөөн ихтэй 8 цэгт, орой шөнийн цагт эргүүлийн 2-6 чиглэлд явган болон хөдөлгөөнт хэлбэрээр эргүүлийн үүрэг гүйцэтгэж ажилласнаар захиргааны зөрчил үйлдсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд 2015 онд 101.306.600 төгрөгний торгуулийг ногдуулсан бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 42.798.600 төгрөг буюу 73.1 хувиар нэмэгдсэн байна.

Мөн Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчсөн 3232 зөрчил илрүүлж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 361 жолоочийг тогтоож, 134 жолоочийг 7-30 хоногийн хугацаатай баривчлуулж, зөрчил гаргасан хүмүүст 27.550.095 төгрөгний торгууль ногдуулж ажилласан байна.

2015 онд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 53 бүртгэгдэж 14 хэргээр буюу 20.8 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Зургаа: Нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагаас зохион явуулж буй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах үүргийн хэрэгжилт;

6.1. Монгол Улсын Хууль зүйн сайдын 2014 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/89 дүгээр тушаалаар баталсан “Иргэний зөвлөл, оршин суугчдад цагдаагийн байгууллагын тайлан тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн ”а”-д заасны дагуу Цагдаагийн газрын 2014 оны үйл ажиллагааны тайланг тус аймгийн нийт иргэдэд 2015 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс 2015 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн хооронд, 2015 оны эхний хагас жилийн тайланг 2015 оны 07 дугаар сард тайлагнав.



Цагдаагийн газрын тайлангийн хурлыг аймгийн төв болох Өлгий сумын ЗДТГ-ын хурлын танхимд зохион байгуулахаас гадна /хуралд аймгийн Засаг дарга, зөвлөлийн гишүүд оролцов/ орон нутгийн “Дербес”, “Наз”, “МИВ2” телевиз, “9 мэдээ”

радиоогоор дамжуулан тайлагнаж, аймгийн иргэдэд хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд тайлангийн хурлын үеэр 6 суманд Цагдаагийн газрын дэргэдэх “Цагаан шонхор” хамтлагийн урлагийн тоглолтыг сонирхуулсан нь иргэдийн анхаарлыг татсан ажил болов.



6.2. Тус аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн даргын 2015 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр баталсан “Өршөөл үзүүлэх тухай хуулиар хорихоос суллагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн дэмжих чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө”-ний дагуу тус Цагдаагийн газар Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр “Өршөөл үзүүлэх тухай” Монгол Улсын хуулийн дагуу хорих байгууллагаас суллагдсан 10 хүнийг “Хөдөлмөрт бэлтгэх” сургалтад хамруулж, ажлын байрны холбогдох төслийг боловсруулан аймгийн Халамж үйлчилгээний хэлтэст хүргүүлсэн бөгөөд өнөөдрийн байдлаар иргэн Д.Бахытбек тус хэлтэсээс 1.200.000 /нэг сая хоёр зуун мянган/ төгрөгний тусламж авсан.



6.3. Мөн аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудыг камержуулах зорилгоор цагдаагийн газраас “Хяналтын камер” ерөнхий арга хэмжээг 2015 оны 03 дугаар сараас эхлэн зохион байгуулсан бөгөөд арга хэмжээний хүрээнд Өлгий сумын төвийн нийт 64 аж ахуйн нэгж, байгууллага өөрсдийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан хяналтын камер суурилуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх болон байгууллагын аюулгүй байдлыг хангахад чухал ажил болсон.



6.4. Баян-Өлгий аймгийн иргэдийн аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, цагдаагийн ажил, үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэх, бие бүрэлдэхүүний ажил үйлс, түүний үр дүнг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд “Цагдаагийн газрын мэдээллийн төв”-ийг 2015 оны 09 дүгээр сард ашиглалтанд оруулан, иргэд, олон нийтийн зүгээс мэдээ, мэдээлэл авах боломжоор бүрэн хангав.



6.5. Цагдаагийн газрын www.bayan-ulgii.police.gov.mn сайтанд зохион явуулсан ажил, арга хэмжээний талаар нийт 29 удаа мэдээ, мэдээллийг байршуулж, цагдаагийн газраас гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх болон бусад чиглэлээр хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээ түүний үр дүнгийн талаар аймгийн радиогоор 22 удаа буюу 97 минут, телевизээр 90 удаа буюу 864 минут, сонин хэвлэлээр 8 удаа нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэж, иргэд, олон нийтэд түгээв.



6.6. Алба хаагчид хариуцсан аж ахуйн нэгж, байгууллага, сум, багуудад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ мэдээлэл, материал нийтлэх, гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, тэдгээрийг арилгуулах талаар иргэн, хуулийн этгээдэд хүлээсэн үүргийнх нь хүрээнд мэдэгдэл хүргүүлж, биелэлтийг шалгах, тасаг, албадын дарга нар алба хаагчдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн ажлыг дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулах журмыг Цагдаагийн газрын даргаар 2014 оны 05 дугаар сарын 19-ний өдөр батлуулж, биелэлтийг тооцож ажиллав.

Журмын хүрээнд цагдаагийн газрын нийт алба хаагч нарыг байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хувиарлан хариуцуулж, цагдаагийн газраас зохион байгуулж байгаа ажил, арга хэмжээ болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад үр дүнтэй ажил болж байгаа бөгөөд 2015 онд нийт 8 сум, 20 байгууллага, аж ахуйн нэгжид болон 3501 хүнд сургалт зохион байгуулав.



Долоо: Олон нийтэд түшиглэсэн цагдаагийн үйл ажиллагааны бодлогын хэрэгжилт;

7.1. “Цагдаагийн албаны тухай” Монгол Улсын хууль болон “Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэм”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор олон нийтийн цагдаагийн ажилтныг судалж, сонгон шалгаруулах үүрэг бүхий 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг Цагдаагийн газрын даргын 2014 оны 07 дугаар сарын

17-ны өдрийн 107 дугаар тушаалаар томилж, олон нийтийн цагдаагийн ажилтны сонгон шалгаруулалтанд хамрагдахыг хүссэн нийт 99 иргэнээс 21 иргэн шалгуур, шаардлагыг хангасан байх тул олон нийтийн цагдаагийн ажилтны гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулсан.



Цагдаагийн газрын даргын 2014 оны 138, 158, 2015 оны Б/02, Б/58, Б/99 дугаартай тушаалаар Өлгий, Толбо, Буянт, Сагсай, Улаанхус, Цэнгэл, Ногооннуур, Алтанцөгц зэрэг сумдад тус бүр 1 /нэг/, нийт 8 /найм/ олон нийтийн цагдаагийн ажилтныг тус тус томилж, хөдөлмөрийн гэрээ байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллаж байна.

7.2. Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн ахлагч бүрэлдэхүүнээс санаачлан тус Цагдаагийн газрын түүхт 75 жилийн ойг угтаж, цагдаагийн газар нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, иргэд, олон нийтийн болон төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлэх, ахлагч бүрэлдэхүүний багаар ажиллах ур чадварыг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах, эмзэг бүлгийг дэмжих зорилгоор “Ахлагчийн 10 хоног” арга хэмжээг 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 2015 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион явуулав.



Арга хэмжээний хүрээнд амьдралын баталгаажих доод түвшинээс доогуур орлоготой, нэн ядуу Өлгий сумын иргэн С.Нурлан, Х.Ерхумар, Ц.Бор, Б.Ерболат

нарын өрхөд 700.000 /долоон зуун мянган/ төгрөгийг цагдаагийн газрын нийт алба хаагч нарын зүгээс дэмжлэг болгон хандивлаж, тус аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс, Нэгдсэн эмнэлэг, “Эрчим” ХХК, “Хайнар” ХХК, Капитрон банк, Улаанзагалмайн хороо зэрэг төрийн болон төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр дээрх өрхүүдэд хоол хүнс болон нэн шаардлагатай эд материалын тусламжийг үзүүлэв.



Мөн ахлагч нарын зүгээс С.Нурлан, Х.Ерхумар нарын гэрт иж бүрэн засвар үйлчилгээ хийж, тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэхээс гадна С.Нурлан, Х.Ерхумар, Ц.Бор, Б.Ерболат нарын гэр бүлийн гишүүд тус бүрт иж бүрэн хувцас, 1 тонн нүүрс, 1 м³ мод, хөнгөлөлттэй цахилгаан болон хүнсний зүйлээр бүрэн хангаж, сэтгэлийн дэм үзүүлэв.



Мөн С.Нурлан, Х.Ерхумар нарыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн Нэгдсэн эмнэлгийн Сайн дурын үндсэн дээр 15 өдөр хор тайлах, архинаас ангиор үйлдвэрүүнд хамруулж, улмаар “Хельп Интернациональ” олон улсын хүмүүнлэгийн байгууллагатай хамтран ажиллах талаар тохиролцоонд хүрч, ядуурлыг бууруулах, эмзэг бүлгийг дэмжихэд дорвитой хувь нэмэр оруулж, улмаар ахлагч бүрэлдэхүүний багаар ажиллах ур чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэв.

7.2. “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлыг тайлагнах, хууль эрх зүйн болон Цагдаагийн байгууллагад хийгдсэн шинэчлэл үйл ажиллагааг сурталчлах, гэмт

хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцдог иргэн, байгууллага, сайн дурын бүлгийн үйл ажиллагааг алдаршуулан сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэн олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх идэвхжүүлэх, хамтын ажиллагааны ач холбогдол хэрэгцээ шаардлагыг ойлгуулах иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Нээлттэй хаалганы өдөр” арга хэмжээг зохион байгуулав. Тухайлбал:



НХЖХ албаны даргаас 2015 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 6/3049 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийг хэрэгжүүлэх зорилгоор “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагааны өдөр” арга хэмжээг Цагдаагийн газрын иргэдийг хүлээж авах танхимд 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зохион явуулав.

7.3. Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон нийтийн итгэл хүлээж иргэний дэмжлэгийг авах, төрийн болон төрийн бус байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдтэй хамтран ажиллах үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх зорилгоор Өлгий сумын 13 багийг хариуцсан хэсгийн байцаагч, багийн Засаг дарга нартай хамтран анх удаа 2015 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн Өлгий сумын 1, 2, 4, 5, 9 дүгээр багуудад “Орцын холбоо”, “Хөршийн холбоо”-г 210 өрхийн дунд байгуулсан.



Уг арга хэмжээг өргөжүүлэх зорилгоор “Олон нийт цагдаагийн хамтын ажиллагааны өдөр”-ийг тохиолдуулан 2015 оны 10, 11 дүгээр сард тус аймгийн Улаанхус, Цэнгэл, Сагсай, Дэлүүн, Толбо, Булган, Ногооннуур сум болон Цагааннуур тосгонд нийт 1490 гишүүнтэй 114 хөршийн холбоо байгуулан ажиллаж байна.

Цаашид аймгийн төвийн багууд болон сумдад “Хөршийн холбоо”-г бүрэн байгуулж дуусгах, “Хөршийн холбоо”-той хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллахаар төлөвлөн ажиллаж байгаа нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг болон гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, үйлдлийг цаг хугацаанд нь таслан зогсоох ач холбогдолтой ажил болсон гэж дүгнэж байна.

7.4. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Өлгий сумын 9 багийг 13 баг болгон өргөжүүлэн зохион байгуулсантай холбогдуулан цагдаагийн ажил, үйлчилгээг багийн иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор 13 багийг 5 хэсгийн байцаагчид хариуцуулж багийн иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлэв.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 34 дугаартай тогтоолоор баталсан “Иргэдийн нийтийн эргүүл ажиллуулах журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2015 онд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоотой 12 удаа иргэдийн нийтийн эргүүлийг зохион явуулав.



7.5. Гэмт хэрэг, зөрчил тэдгээрийн үйлдэгдэж байгаа цаг хугацааны байдалд дүгнэлт өгч, Цагдаагийн газрын НХЖХТасаг, ЗЦТасгийн алба хаагчид зөрчил ихээр үйлдэгдэж байгаа цаг хугацаанд хамтран ажиллаж, өдрийн цагаар аймгийн төвийн хөдөлгөөн ихтэй 8 цэгт, орой шөнийн цагт эргүүлийн 2-6 чиглэлд явган болон хөдөлгөөнт хэлбэрээр эргүүлийн үүрэг гүйцэтгэж ажиллав.



7.6. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Ногоон гэрэл-цагаан шугам 2015” тэмцээнд тус аймгийн “Зайд” бүрэн дунд сургуулийн Б.Гүлдаурен багштай 3 дугаар ангийн сурагчид болох Г.Авдуллах, Т.Аймжан, Б.Ергалым, М.Тансауле, А.Нурдаулет, О.Нурбота нарыг тус Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн алба хаагч нар мэргэжлийн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлэн уралдаан тэмцээнд амжилттай оролцуулав.

Тэмцээнд оролцсон сурагчид багаараа тусгай байранд шалгарч, багийн ахлагч Г.Авдуллах нь авхаалж самбаагаараа бусдыг хошуучлан нийслэлийн “Шилдэг хүүхэд”-ээр шалгаран алтан медалиар шагнуулав.



“Ногоон гэрэл-цагаан шугам 2015” тэмцээнд оролцох боломжоор хангаж өгсөн “Зайд” бүрэн дунд сургуулийн захирал З.Жолаушыбай болон багш, сурагчдыг Цагдаагийн газрын баярын бичиг болон гарын бэлэг гардуулах ажлыг зохион байгуулав.


7.7. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй, соёлтой оролцох дадал эзэмшүүлэх, даатгалын тухай ойлголт өгөх, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор Цагдаагийн газар нь аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, Албан журмын даатгуулагчдын холбоотой

хамтран 2015 оны 10 дугаар сарын 29, 30-ны өдрүүдэд “Бяцхан цагдаа-2015” тэмцээнийг зохион явуулав.



7.8. Дусал цус хүний амь авардаг гэдэг. Нэг хүний өгсөн цусаар гурван ч хүний амийг авардаг буяны үйлс. Тиймдээ ч цусаа өгсөн та баатар мөн хэмээдэг.

Хүнд амьдрал хайрладаг энэ буянт үйлст нэгдэх сонирхолтой хүмүүс цөөнгүй байдаг ч, өдөр тутмын ажил амьдралын хэмнэлд түүртэн тэр бүр цаг гаргаж чадахгүй байх нь элбэг байдаг тул цагдаагийн газрын зүгээс бусад аж ахуй нэгж, байгууллагуудыг донор болох хүмүүнлэгийн үйлсэд хамрагдахыг уриалан, бие бүрэлдэхүүн нэгдсэн зохион байгуулалтайгаар Цусны төв цусаа хандивлах сайн дурын хүмүүнлэгийн үйл ажиллагааг 2015 оны 04, 09 дүгээр саруудад зохион байгуулав.



Найм: Бусад шаардлагатай асуудлаар;

8.1. Өмнөд Судан Улс дахь Нэгдсэн үндэстний байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд Цагдаагийн байгууллагын хэмжээнд нийт 27 алба хаагч үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд тус Цагдаагийн газрын Ногооннуур сум дахь хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч Хасиханы Серикбол үүрэг гүйцэтгэж байгаа нь НҮБ-ын үйл ажиллагаанд дэмжлэг, сайн санааны туслалцаа үзүүлэх, зуучлах, эвлэрүүлэх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх, олон улсын цэргийн болон хүмүүнлэгийн байгууллагуудтай хамтран ажиллах бодлогын хэрэгжилтэнд тодорхой хувь нэмэр оруулав.



8.2. 2015 онд тус аймгийн Бугат, Сагсай тосгонд цагдаагийн бичил хэсгийн байр /кобан/ бариулах хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөвт суулгуулж, цагдаагийн бичил байрны барилгын ажлыг хийх гүйцэтгэгчийг шалгаруулан, гүйцэтгэгчээр “Ашекей” ХХК, “Досстрой” ХХК ажиллаж, нийт 156.449.930 /нэг зуун тавин зургаан сая дөрвөн зуун дөчин есөн мянга есөн зуун гучин/ төгрөгөөр барьж 2015 оны 09 дүгээр сард ашиглалтанд оруулсан.

Тус аймаг нь 12 сум, 1 тосгонтой бөгөөд 2015 онд Цагдаагийн бичил байр /кабан/ бүрэн баригдаж дууссан бөгөөд сумдад ажиллаж, амьдарч байгаа цагдаагийн алба хаагч нарын нийгмийн баталгааг хангасан томоохон ажил болов.



8.3. Сум дахь хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх ажлын хүрээнд цагдаагийн кобаны халаалтанд Цагдаагийн газрын төсвөөс 95 тонн буюу 9.900.000 /есөн сая есөн зуун мянган /төгрөгний нүүрсийг олгов.

8.4. Өлгий сумын 9 дүгээр багт Цагдаагийн кобан барих зориулалттай 30 жилийн хугацаатай 0.072 м/кв эрхийн бичигтэй газар эзэмшиж байгаа бөгөөд Өлгий сумын алслагдсан тодорхой багуудад цагдаагийн ажил, үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх, ая тухтай орчинд иргэдэд үйлчилгээ үзүүлэх, тэнд ажиллаж байгаа

цагдаагийн алба хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Цагдаагийн үйлчилгээний бичил төв”-ийг барьж байгуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг 2015 оны аймгийн төсвийн давсан хэсгээс шийдвэрлүүлэхээр аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал оруулаад байна.



8.5. Цагдаагийн газарт ажиллаж байгаад цэргийн алба хаасны тэтгэвэрт гарсан 57 /тавин долоо/ ахмад ажилтанд Монголын “Цагаан сар” болон Казах ард түмний “Наурыз”-ын баярыг тохиолдуулан хүндэтгэл үзүүлж, 570.000 /таван зуун далан мянган/ төгрөгний тусламжийг 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн Б/13 дугаар тушаалаар олгож, 10 ахмад ажилтанд дурсгалын мөнгөн аяга, хадагын хамт гардуулан хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулан ажиллаж байна.



8.6. Алба хаагч нарын ажлыг сар бүр шударга дүгнэж үр бүтээлтэй ажилласан 334 алба хаагчийн сарын үндсэн цалинг интервалаар 5-20 хувь буюу нийт 34.107.535 /гучин дөрвөн сая нэг зуун долоон мянга таван зуун гучин таван мянган/ төгрөгийг нэмж олгож, алба хаагч нарын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авав

8.7. “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэгт заасан “Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчид 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшлыг таван жил

тутам олгох бөгөөд мөнгөн урамшил олгох журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу тус Цагдаагийн газарт 5 /тав/ дээш жил суманд тогтвортой ажиллаж байгаа 3 алба хаагчид 32.000.000 /гучин хоёр сая/ орчим төгрөгний урамшуулал олгож, алба хаагчдын хөдөө сумдад тогтвортой ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангав.

8.8. Аймгийн Татварын хэлтэстэй хамтарч ажилласнаар 2015 онд 6165 тээврийн хэрэгслийн татвар болох 260.362.959 /хоёр зуун жаран сая гурван зуун жаран хоёр мянга есөн зуун тавин есөн/ төгрөг, 1321 галт зэвсгийн татвар болох 6.754.100 /зургаан сая долоон зуун тавин дөрвөн мянга нэг зуун/ төгрөгийг тус тус төвлөрүүлэн ажиллав.



8.9. Албан журмын даатгагчдын холбооны салбар болон аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 9 даатгалын салбартай хамтран 2015 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 7738 жолоочийг хариуцлагын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулж, даатгалын санд 248.692.036 /хоёр зуун дөчин найман сая зургаан зуун ерөн хоёр мянга гучин зургаан/ төгрөгийг хуримтлуулав.

8.10. Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус аймаг дахь Цагдаагийн газрын орчинд мод тарих ажлыг 2015 оны 10 дугаар сарын 11-ний өдөр буюу “Бямба” гарагт нийт алба хаагчдыг оролцуулан зохион байгуулав. Уг ажлын хүрээнд 200.000 /хоёр зуун мянган төгрөг/-ийн өртөгтэй 98 ширхэг модыг тарьсан ба уг арга хэмжээнд Цагдаагийн газрын бие бүрэлдэхүүн идэвхтэй оролцов.



8.11. Тус Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа М.Батболд нь ЦЕГ-ын даргын 2015 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн Б/415 дугаар тушаалаар 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөс 31-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөрмонголын Өөртөө Засах Орны Хөх хотод зохион байгуулагдсан цагдаагийн байгууллагын удирдах түвшний алба хаагчдад зориулсан удирдахуйн сургалтад оролцов.




8.12. Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2015 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 1-01/739 дугаартай албан бичгийг үндэслэн ЦЕГ-ын Гадаад харилцааны хэлтсийн даргын 2015 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 3г/1621 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу 2015 оны 03 дугаар сарын 30-наас 04 дүгээр сарын 02-ны өдрийн хооронд ОХУ-ын БН Тува Улсын Кызыл хотод “Боловсрол, соёл, нийгэм-эдийн засаг, хууль эрх зүйн асуудал болон хил дамнасан мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, урьд өмнө нь үйлдэгдсэн гэмт хэргүүдийг илрүүлэх” зорилгоор зохион байгуулсан хамтарсан уулзалтанд тус Цагдаагийн газрын дарга, холбогдох алба хаагч нар оролцлоо.



Уулзалтанд оролцсноор Баян-Өлгий аймаг дахь Цагдаагийн газар болон БН Тува Улсын Дотоод явдлын яамны удирдлага, эдгээр байгууллагуудын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий хэлтэс, хэсгийн алба хаагч нарын хооронд итгэлцэл бий болж, харилцан бие биенийхээ ажлыг хүндэтгэн, хуулийн хүрээнд түргэн шуурхай мэдээлэл солилцон, дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахаар болов.

8.13. ЦЕГ-ын Гадаад харилцааны хэлтсийн 2015 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 2в/5035 дугаартай албан бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу хил дамнансан эзэнгүй мал хулгайлах гэмт хэргийг илрүүлэх ажлын хүрээнд ОХУ-ын БН Алтай Улсын Цагдаагийн байгууллагын холбогдох алба хаагч нартай хамтран тус Цагдаагийн газрын Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга, цагдаагийн хошууч Б.Хайырлыс, ахлах мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад О.Асылбек нар хохирогч нарын хамт 2015 оны 09 дүгээр сарын 26-наас 30-ны өдрүүдэд ОХУ-ын БН Алтай Улсын нутаг дэвсгэрт ажиллаа.



8.14. ЦЕГ-ын Гадаад харилцааны хэлтсийн 2015 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 2в/4120 албан бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу ОХУ-ын БН Алтай Улсын Кош-Агач дүүрэг дэх Цагдаагийн хэлтсийн дарга болон эрх бүхий алба хаагч нартай мэдээ мэдээлэл солилцох зорилгоор тус Цагдаагийн газрын дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Н.Ууганбаяр, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэсгийн дарга, цагдаагийн хошууч Б.Хайырлыс, ахлах мөрдөн

байцаагч, цагдаагийн ахмад О.Асылбек, жолооч цагдаа, цагдаагийн дэд ахлагч Э.Энхжаргал нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг уулзалт зохион байгуулав.

8.15. Баян-Өлгий аймаг дахь Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дунд уламжлал болгон зохион байгуулдаг “Оны аварга шалгаруулах спортын цогцолбор тэмцээн”-ийг Зэвсэгт хүчний 340 дүгээр анги 2015 оны 12 дугаар сарын 04, 05, 06-ны өдрүүдэд аймгийн Биеийн тамир, спортын газарт зохион байгуулсан. Уг тэмцээнд тус Цагдаагийн газрын баг, тамирчид амжилттай оролцож багаараа **“ТЭРГҮҮН”** байр эзэлж, өргөмжлөл, алтан медаль, шилжин явах цомоор шагнуулав.



8.17. Алба хаагчдын хамтач уур амьсгалыг бүрдүүлэх, багаар ажиллах ур чадвар, бүтээлч сэтгэлгээг дээшлүүлэх болон алба хаагчдын амьдрах нөхцөл, бололцоо, нийгмийн асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэж, цагдаагийн газрын өнгө үзэмжийг сайжруулах, иргэдэд ая тухтай орчинд ажил үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Бид нэг хамт олон” аяныг 2015 онд үргэлжлүүлэн зохион байгуулж, 12.5 сая төгрөгний үнэ бүхий бүтээн байгуулалт хийв.



8.18. Цагдаагийн газрын алба хаагчид хуваарийн дагуу аймгийн төвөөс Сагсай сумруу явах замын урьд талын газрыг тогтоосон хугацаанд 5 удаа цэвэрлэж, “Эрүүл орчинтой, тохилог хотод амьдарцгая” уриан доор “Хотын тохижилт, ариун цэврийн талаар баримтлах журам”-ыг үйл ажиллагаанд хэрэгжүүлж,

нийтийн цэвэрлэгээний ажилд цагдаагийн газрын зүгээс идэвх санаачлагатай бусад байгууллагуудыг манлайлан оролцож, Өлгий хотын өнгө үзэмжийг сайжруулахад тодорхой хувь нэмэр оруулав.

8.19. Баян-Өлгий аймагт Цагдаагийн байгууллага үүсэн байгуулагдсаны түүхт 75 жилийн ойн баярын арга хэмжээ аймгийн төвд 2015 оны 07 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд ёслол төгөлдөр зохион байгуулагдлаа. Баярын үеэр цагдаагийн газрын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, тэргүүний алба хаагчдыг алдаршуулах, ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх, зэрэг үйл ажиллагаа явагдахаас гадна ойн баярт зориулсан бэсрэг наадам зохион байгуулагдлаа.



8.20. Баян-Өлгий аймаг дахь цагдаагийн газар тус аймгийн “2015 ОНЫ ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГА”-аар шалгарч гэрчилгээ, үнэ бүхий зүйлээр шагнууллаа.

Цагдаагийн газрын хамт олны нөр их хүч, хөдөлмөр, хичээл зүтгэлийг аймгийн удирдлагууд, иргэдийн төлөөлөгчид үнэлж, “Шилдэг байгууллага”-аар шалгаруулсан явдал нь тус цагдаагийн газар үүсч байгуулагдсан түүхэн 75 жилийнхээ хугацаанд анх удаагаа аймгийн шилдэг, тэргүүний байгууллагаар шалгарч манай байгууллагын түүхэнд онцлон тэмдэглэх үйл явдал боллоо.



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР